



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 24 өдөр

Дугаар А/595

Булган сум

Гадаад албан томилолтоор ажиллуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.9, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Сангийн сайдын “Гадаад албан томилолтын зардлын хэмжээ шинэчлэн батлах тухай” 2011 оны 188 дугаар тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX/08 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах албаны ажилтан Эрдэнэбилэгийн Эрболд, Тулгаагийн Хонгорзул, Энхжаргалын Манлайбаатар, Булган аймгийн Иргэдийн Хурлын Төлөөлөгч Мягмаржамцын Бат-Орших нарыг 2024 оны 09 дүгээр сарын 03-08-ны өдрүүдэд БНСУ-ын Гёнги аймгийн Шинхан их сургуулийн хамтын ажиллагааны хүрээнд шинээр элсэн суралцаж буй оюутнуудыг хүргэж өгөх, мөн суралцаж буй Булган аймгийн оюутнуудтай уулзах, ярилцлага, видео бичлэг, контент хийх зэрэг ажлаар албан томилолтоор ажиллуулсугай.

2.Албан томилолтод шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын хуулиар олгогдсон зарим чиг үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ



0324510804